



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 21 өдөр

Дугаар А/113

Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2022 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн А/126 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсад Мал эмнэлэг, үржлийн алба үүсч хөгжсөний 100 жилийн ой 2023 онд тохиож байгаатай холбогдуулан ойн, арга хэмжээний бэлтгэлийг хангах, зохион байгуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Б.Оюунтуяа

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга)

Гишүүд :

Я.Эрхэмбаяр

(Аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газрын дарга)

Л.Ариунаа

(Аймгийн Мал эмнэлгийн газрын дарга)

Д.Чинзориг

(Хөгжлийн бодлого, төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтсийн хүнс, хөдөө аж ахуй, бодлого, үйл ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн)

Г.Баттулга

(Хөвсгөл аймгийн мал зүйч үржүүлэгчдийн холбоо ТББ-ын тэргүүн)

С.Эрдэнэцэцэг

(Монголын үндэсний мал эмнэлгийн холбооны Хөвсгөл аймаг дахь салбар зөвлөлийн дарга)

Нарийн бичгийн дарга:

Б.Бямбасүрэн

(Хүнс Хөдөө Аж Ахуйн газрын Мал үржлийн албаны дарга)

Б.Мягмарсүрэн

(Мал эмнэлгийн газрын мал амьтны эрүүл мэндийн албаны дарга)

2. Мал эмнэлэг, үржлийн алба үүсэн байгуулагдсаны 100 жилийн ойн хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулан баталж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Оюунтуяа)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Захирамж-2023

671:010476